



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Арбулаг сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2025/028/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Мөрөн сум 2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamd@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран

Утас: 92118277 Цахим хаяг: MandakhnaranL@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б			
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	1,700.7	1,687.6	-13.1
Бараа материал	148,330.5	163,348.2	15,017.6
Үндсэн хөрөнгө	1,523,520.0	1,843,637.0	320,117.0
Нийт хөрөнгө	1,673,551.3	2,008,672.8	335,121.5
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,673,551.3	2,008,672.8	335,121.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,673,551.3	2,008,672.8	335,121.5

Аудитаар нийт 2,947.1 мянган төгрөгийн зөрчил¹ илрүүлж, 2,947.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Тус байгууллагын Тэвхэн ХХК-иас худалдан авсан бараа, материалыг тулган баталгаажуулалт хийхэд төсвийн хөрөнгөөр 2,947.1 мянган төгрөгийн согтууруулах ундаа болон байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй материал худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6 дахь "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх," 15.1.7 дахь "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах" заалттай нийцэхгүй ба "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

5.2.1 Ахмадын сан

Хөвсгөл аймгийн Арбулаг сумын ЗДТГ нь "Ахмадын сан" байгуулаагүй бөгөөд тайлант онд тус байгууллагад ажиллаж байсан ахмад настнуудад зориулж нийт 1,480.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална" заалт, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-тай тус тус нийцэхгүй ба "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагад ажиллаж байсан ахмадуудад зориулж төсөв зарцуулахдаа Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын дагуу ахмадын сан байгуулж тус сангийн журмыг мөрдөж ажиллах

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Албан бус хэрэгцээний материал худалдан авсан	1	2,947.1	1	2,947.1								
Дүн	1	2,947.1	1	2,947.1			1					

Нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Ахмадын сан байгуулж ажиллаагүй	1	0.0					1	0.0				
Дүн	1	0.0	0	0.0	0	0.0	1	0.0	0	0.0	0	0.0